



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

“Хан-Уул Яармаг” ОНӨААТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 59,700,000.00 (тавин есөн сая долоон зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул Яармаг ОНӨААТҮГ (Б.Амартүвшин)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ (В.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

